



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/328

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 3/03 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 3 дугаар зүйлийн 3.3, аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд “COVID-19”-ын цар тахалын гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын үед үүрэг гүйцэтгэж буй Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагчдад олон үйлдэлт энгэрийн тэмдэг авах, постуудад ашиглаж буй гэрүүдийн салхи шуурганы улмаас үүссэн хохиролын сэргээн босголтын зардал, Жаргалант сумын 12 багийн гэрт амьдардаг иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор өрх бүрт олгосон нүүрсний зардал зэрэгт нийт 32901.0 мянган төгрөг /гучин хоёр сая есөн зуун нэг мянган/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 32901.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын 2021 оны батлагдсан нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/328-Bo
02 1785

Аймгийн Засаг даргын 2021 оны
07 дугаар сарын 05-ны өдрийн
А/328 дугаар захирамжийн хавсралт



“COVID-19”-ЫН ЦАР ТАХАЛЫН ГАМШГААС ХАМГААЛАХ
ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДАЛ

ДД	Үзүүлэлт	Зориулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ /төгрөг/	Бүгд үнэ /мянган төгрөг/
1	Аймгийн цагдаагийн газар	Олон үйлдэлт энгэрийн тэмдэг	ш	25	540000.00	13500.0
2	Онцгой байдлын газар	Гэрийн бүрээс, бүс, хаяавч, өрхний өнгө	ш	4	250000.00	1000.0
3	Эрдэнэбүрэн сум	Гэрийн бүрээс, бүс, хаяавч, өрхний өнгө	ш	2	250000.00	500.0
4	Жаргалант сум	Нүүрс тээврийн хөлс	ш	8	1500000.00	12000.0
		Нүүрсийг айл өрхөд хүргэсэн зардал	баг	12		2092.8
		Нүүрс савлах үеийн хоол хүнсний зардал	ш	1		741.0
		Нүүрс савлах уут, шуудайн зардал	ш	4500	450.00	2025.0
		Нүүрс савлах уут, шуудайн зардал	ш	2100	400.00	840.0
		Бусад материалын зардал				202.2
		Дүн				17901.0
Нийт дүн						32901.0

-oOo-